



## ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**Аудитын нэр:** “Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудит

ҮАГ- ХОА/2017/10-ГА

Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2017 оны А/12 дугаар тушаал, Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

***Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хуульд заасан татварын чөлөөлөлтийг эдлэхгүй байна.***

Ховд хот

2017 оны 8 сар

|                                                                                                                                                                    |                                                                                                                                                                                                                                                                       |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Тайланг бэлтгэсэн:</b>                                                                                                                                          | Товчилсон үгийн тайлбар .....3                                                                                                                                                                                                                                        |
| <b>Ховд аймаг дахь<br/>Төрийн Аудитын<br/>газар</b>                                                                                                                | Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга<br>зүй.....4                                                                                                                                                                                                                     |
| <b>Тэргүүлэх аудитор</b>                                                                                                                                           | Ерөнхий зүйл.....5                                                                                                                                                                                                                                                    |
| Л.Галбадрах                                                                                                                                                        | <b>Бүлэг 1: Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд<br/>албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг<br/>холбогдох хуулиудын дагуу эдэлж байгаа ч<br/>төрийн байгууллагуудын нэгдсэн<br/>хөнгөлөлт чөлөөлөлт эдлүүлсэн мэдээ<br/>судалгаа хоорондоо уялдахгүй байна.....6-8</b> |
| <b>Аудитын менежер</b>                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                                                                       |
| А.Цэцэгсүрэн                                                                                                                                                       |                                                                                                                                                                                                                                                                       |
| <b>Ахлах аудитор</b>                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                       |
| Д.Хишгээ                                                                                                                                                           |                                                                                                                                                                                                                                                                       |
| <b>Аудитор</b>                                                                                                                                                     |                                                                                                                                                                                                                                                                       |
| Д.Нарантуул                                                                                                                                                        | 1.1.Татварын хуульд заасан хөнгөлөлт,<br>чөлөөлөлтөнд хамрагдсан ААН-ын нэгдсэн<br>судалгаа аймгийн хэмжээнд байхгүй байна.                                                                                                                                           |
| Д.Мөнхтулга                                                                                                                                                        |                                                                                                                                                                                                                                                                       |
| Д.Эрдэнэцэцэг                                                                                                                                                      |                                                                                                                                                                                                                                                                       |
| Д.Балжинням                                                                                                                                                        | <b>Бүлэг 2:Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд<br/>тавих хяналт хангалтгүй байна.</b>                                                                                                                                                                                     |
| <b>2017 оны 08 дугаар<br/>сар</b>                                                                                                                                  | 2.1. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд тавих<br>хяналт хангалтгүй байна.                                                                                                                                                                                                |
| <b>Уг тайланг УАГ-ын<br/>Веб сайт-аас үзнэ үү.</b>                                                                                                                 |                                                                                                                                                                                                                                                                       |
| <b><a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></b>                                                                                                              | Дүгнэлт.....13                                                                                                                                                                                                                                                        |
| Аудитын тайлан,<br>дүгнэлттэй холбоотой<br>асуудлаар нэмж<br>тодруулах, асууж<br>лавлах зүйл байвал<br>70433061 дугаарын<br>утас дугаарын факсаар<br>харилцана уу? | Зөвлөмж.....13                                                                                                                                                                                                                                                        |
| <b>ХАЯГ:</b> Ховд аймгийн<br>ЗДТГ-ын байр 3<br>давхарт                                                                                                             | Зөрчлийн жагсаалт..... 14                                                                                                                                                                                                                                             |
|                                                                                                                                                                    | Тэргүүлэх аудиторовын тушаал ..... 15                                                                                                                                                                                                                                 |

**Товчилсон үгийн тайлбар:**

| <b>Товчилсон үг</b> | <b>Тайлбар</b>                                  |
|---------------------|-------------------------------------------------|
| <b>АДБОУС</b>       | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт   |
| <b>ҮАГ</b>          | Үндэсний аудитын газар                          |
| <b>ГАГ</b>          | Гүйцэтгэлийн аудитын газар                      |
| <b>ГА</b>           | Гүйцэтгэлийн аудит                              |
| <b>ИТХ</b>          | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал                    |
| <b>ЗДТГ</b>         | Засаг даргын тамгын газар                       |
| <b>СТСХ</b>         | Санхүү, төрийн сангийн хэлтэс                   |
| <b>БОАЖГ</b>        | Байгаль орчин, аялал жуулчлалын газар           |
| <b>ОӨУБГ</b>        | Оюуны өмч, улсын бүртгэлийн хэлтэс              |
| <b>ГЕГ</b>          | Гаалийн ерөнхий газар                           |
| <b>ХХОАТ</b>        | Хувь хүний орлогын албан татвар                 |
| <b>НӨАТ</b>         | Нэмэгдсэн өртгийн албан татвар                  |
| <b>ТЕГ</b>          | Татварын ерөнхий газар                          |
| <b>ААН</b>          | Аж ахуйн нэгж                                   |
| <b>ТХБ</b>          | Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй                  |
| <b>ХХК</b>          | Хязгаарлагдмал хариуцлагатай компани            |
| <b>ЭМНДХ</b>        | Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс           |
| <b>ГХБХБГ</b>       | Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар |
| <b>АТГ</b>          | Авто тээврийн газар                             |
| <b>ХЧ</b>           | Хөдөлмөрийн чадвар                              |

## **Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй:**

**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2017 оны А/12 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

**Аудитын зорилт:**Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүнг шалгаж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаарх бодлого, зохицуулалт үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх.
- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд тавих хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх.

**Аудитын хамрах хүрээ:**Татварын хуулийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаарх бодлого, судалгаа, шинжилгээ, статистик мэдээ, бусад баримт материалд үндэслэн аймгийн ЗДТГ-ын СТСХ, Татварын хэлтэс, БОАЖГ, ОӨУБГ, ГЕГ-ын харъяа Ховд аймаг дахь Гаалийн газар болон бусад холбогдох газруудыг 2015-2016 оны байдлаар хамруулан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөнд аудит хийлээ.

**Аудитын арга зүй:**Аудитыг гүйцэтгэхэд төрийн хяналт, шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/-ийг ашиглах, холбогдох агентлаг, аймгийн ИТХ-ын холбогдох албан тушаалтнууд болон Татварын хэлтсийн ажилтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, үйл ажиллагааны тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

**Шалгуур үзүүлэлтүүд:**Аудитад Төрийн аудитын тухай хууль,Үндэсний хөгжлийн цогц бодлого,Татварын Ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль,Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль,Гаалийн тариф, гаалийн албан татварын тухай хууль,Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль,Хувь хүний орлогын албан татварын тухай хууль,Онцгой албан татварын тухай хууль,Төсвийн тухай хууль,Төрийн аудитын тухай хуулиуд болон хуулиудтай нийцүүлэн гаргасан дүрэм, журам, холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд. дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

### **Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:**

Аудитыг Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Л.Галбадрах удирдан, аудитын менежер А.Цэцэгсүрэн аудитын арга зүйгээр хангаж, үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, Ахлах аудитор Д.Хишгээ, аудитор Д.Нарантуул, Д.Мөнхтулга, Д.Балжинням, Д.Эрдэнэцэцэг нар гүйцэтгэв.

### **ЕРӨНХИЙ ЗҮЙЛ:**

Татварын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлд заасан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг гагцхүү хуулиар ноогдуулахаар заасны дагуу ААНОАТ тухай хууль, ХХОАТ тухай хууль, Онцгой албан татварын тухай, НӨАТ-ын тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай, Бууны албан татварын тухай, газрын төлбөрийн тухай, Тэмдэгтийн хураамжийн тухай хуулиудаар нийт 248 хөнгөлөлт, чөлөөлөт эдлэх хуулийн заалтууд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Татварын Ерөнхий газраас ирүүлсэн судалгаагаар Ховд аймагт НӨАТ-ын тухай хуулийн дагуу 2015 онд 32 аж ахуйн нэгжүүд 1711.5 сая төгрөг 2016 онд 20 аж ахуйн нэгжүүдэд 717,8 сая төгрөгийн борлуулалтын орлогын чөлөөлөлт эдэлсэн байна. Харин Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас 2015 онд 1 ААН 528.1 сая төгрөг, 2016 онд 6 аж ахуйн нэгж 1297.7 төгрөгийн борлуулалтын орлогод ноогдох татвараас хөнгөлөгдсөн байна.

Хувь хүний орлогын албан татварын хуулийн дагуу хөнгөлөлт чөлөөлөлт эдлэх 1904 иргэдийн материалыг шалган 818,9 сая төгрөгийг буцаан олгохоор баталгаажуулж, хуульд заасан хугацаанд шалгаж баталгаажуулан аймгийн СТСХ-т хүргүүлсэн байна. Үүнд орон сууцны хөнгөлөлт анх удаа эдэлж байгаа 203 иргэн 164,7 сая төгрөг, 2-оос дээш жил эдэлж байгаа 648 иргэний 442,4 сая төгрөг, сургалтын төлбөрийн хөнгөлөлтөнд 851 иргэдийн 607,2 сая төгрөгийн хөнгөлөлт чөлөөлөлт эдлүүлэхээр тушаал гарган татварын буцаалтыг олгожээ.

2016 оны байдлаар ААНОАТ төлөгч 1789 аж ахуйн нэгж, НӨАТатвар төлөгч давхардсан тоогоор 3958 аж ахуйн нэгж бүртгэлтэй байна. Үүнээс ААНОАТ-ын тайланг 1559 аж ахуйн нэгж байгууллага тайлан тушааж 91,1 хувьтай, НӨАТ-ын тайланг давхардсан тоогоор 3912 аж ахуйн нэгж тушааж 98,8 хувьтай тайлан хүлээн авч ажиллажээ.

**Бүлэг 1: Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг холбогдох хуулиудын дагуу эдэлж байгаа ч төрийн байгууллагуудын нэгдсэн хөнгөлөлт чөлөөлөлт эдлүүлсэн мэдээ судалгаа хоорондоо уялдахгүй байна.**

**Татварын хуульд заасан хөнгөлөлт, чөлөөлөлтөнд хамрагдсан ААН-ын нэгдсэн судалгаа аймгийн хэмжээнд байхгүй байна.**

**1.1 Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай** хуулийн дагуу 2015 онд 1, 2016 онд 6 аж ахуйн нэгж хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан байна.

| Он   | ААН-ийн тоо |                      |            |                      |            |                      |
|------|-------------|----------------------|------------|----------------------|------------|----------------------|
|      | Чөлөөлөлт   |                      | Хөнгөлөлт  |                      | ДҮН        |                      |
|      | ААН-ын тоо  | Мөнгөн дүн /сая.төг/ | ААН-ын тоо | Мөнгөн дүн /сая.төг/ | ААН-ын тоо | Мөнгөн дүн /сая.төг/ |
| 2015 | 1           | 332.2                |            |                      | 1          | 332.2                |
| 2016 | 4           | 520.4                | 2          | 129.6                | 6          | 650.0                |

Хөнгөлөлтөнд хамрагдсан:

- Үр жимс хоршоо нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 19 дугаар зүйлийн 19.1.1<sup>1</sup>-д заасан заалтаар үр тариа, төмс, хүнсний ногооны чиглэлээр 70,2 сая төгрөгийн борлуулалтын орлогын,
- Цэцэгт чандмань ХХК нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 19 дугаар зүйлийн 19.1.2<sup>2</sup>-д “заасны дагуу сүүний чиглэлээр 59,4 сая борлуулалтын орлогын чөлөөлөлтийг эдэлсэн байна.
- Тухайн аж ахуйн нэгжүүдэд Татварын ерөнхий хуулийн дагуу татварын хөнгөлөлт чөлөөлөлтөнд хамрагдах хүсэлт, холбогдох баримтуудыг үндэслэн Татварын хэлтсийн даргын 2017 оны 07 сарын 25-ны Дугаар А/32 тоот тушаалаар албан татвараас чөлөөлсөн байна.

**1.2. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай** хуулийн холбогдох заалтын дагуу 2015 онд 32, 2016 онд 21 аж ахуйн нэгж нийт 52 НӨАТ төлөгчдийн 2429.3 сая төгрөгийн борлуулалтыг НӨАТатвараас чөлөөлсөн байна.

Судалгаагаар ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийн анхан шатны баримтыг түүвэрлэн шалгахад Хатан түнхэл ХХК нь НӨАТ-ын хасалт буцаалтын 66,0 сая төгрөгийн худалдан авалтын орлогыг НӨАТ-ын хөнгөлөлт чөлөөлөлтийн орлого гэж буруу тайлагнасан байна.

**1.3 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай** хуульд заасны дагуу элбэг ургамал ашигласан иргэн, ховор ургамалыг судалгаа шинжилгээний зориулалтаар ашигласан иргэн ААН хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхээр заагдсан ч энэ хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдэлсэн иргэн, байгууллагын нэгдсэн судалгаа

<sup>1</sup> гишүүдийнхээ бүтээгдэхүүнийг худалдах үйл ажиллагааны зуучлалын үнийн зөрүүгээс олсон хоршооны орлого

<sup>2</sup> 25-аас дээш ажиллагчидтай аж ахуйн нэгжийн нийт ажиллагсдын 2/3 ба түүнээс дээш хувийг хараагүй ажилтан эзэлдэг бол уг аж ахуйн нэгжийн орлого”

байхгүй байна. Нөгөөтөйгээр тус хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-д “Элбэг ургамал ашигласны төлбөрийг хөнгөлж болох бөгөөд төлбөрийг хөнгөлөх нөхцөл, болзол, хувь, хэмжээг тухайн орон нутгийн нөхцөл, онцлог байдлыг харгалзан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно” гэж заасан ч аймгийн ИТХ-аас энэ талаар гаргасан тогтоол байхгүй байна.

**1.4 Галт зэвсгийн албан татварын тухай** хуулийн дагуу музейн үзмэр, иргэний болон харуул хамгаалалтын зориулалтаар ашиглаж байгаа, байгаль хамгаалагчийн эзэмшилд байгаа галт зэвсгийг татвараас чөлөөлөх заалтаар музейн 17 буу, театрын 9 буу татвараас чөлөөлөгдсөн байна. Аймгийн хэмжээнд байгаль хамгаалагчийн эзэмшилд ашиглаж байгаа галт зэвсэг байхгүй байна.

**1.5. Гаалийн тариф, гаалийн татварын тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай** хуулиудаар 2015 онд 13 аж ахуйн нэгжид 25042.6 сая төгрөгийн барааны үнэ, 2016 онд 7 аж ахуй нэгжид 26142.5 сая төгрөгийн барааны үнийн чөлөөлөлт, хөнгөлөлт үзүүлсэн байна. Уг татварын хөнгөлөлтөнд олон улсын гэрээгээр замын ажил гүйцэтгэж байгаа Эйч Кэ Би интернэшнл холдинг ХХК, "Jiangsu jianda Construction", Чайна хуаши энтерпрайзиз ХХК зэрэг гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд хамрагдсан байна.

Олон улсын гэрээгээр замын ажил гүйцэтгэж байгаа гадаадын компануудын гаалиар оруулж ирсэн замын материалын хөнгөлөлт чөлөөлөлт эдэлсэн судалгааг хүснэгтээр харуулбал.

| Д/Д | Он   | Компаний нэр                     | Материалын нэр | Гаалиар оруулсан хэмжээ/кг/ |
|-----|------|----------------------------------|----------------|-----------------------------|
| 1   | 2015 | "Jiangsu jianda Construction"    | цемент         | 12.345.000                  |
| 2   | 2016 | "Jiangsu jianda Construction"    | цемент         | 470.000                     |
| 3   | 2016 | Чайна хуаши энтерпрайзиз         | цемент         | 643.000                     |
| 4   | 2016 | Чайна хуаши энтерпрайзиз         | арматур        | 186.994                     |
| 5   | 2016 | Эйч Кэ Би интернэшнл холдинг ХХК | цемент         | 200.000                     |

Эх сурвалж: Гаалийн газрын мэдүүлгээр

Тухайн компаниуд Ховд аймгийн татварын хэлтэст бүртгэлгүй учир хөнгөлөлт чөлөөлөлтийн төсөвт өртгийг ААГ-аас хянах боломжгүй тул цаашид харьяалагдах татварын хэлтсээр дамжуулан сангийн яамнаас баталсан төсөвтэй тулгаж хөнгөлөлт чөлөөлөлт эдэлсэн бараа материалын зарцуулалтыг нягтлан үзэх шаардлагатай байна.

Хуульд жижиг дунд үйлдвэрлэлийн зориулалтаар импортоор оруулж ирж буй тоног төхөөрөмж чөлөөлөгдөхөөр заасан байхад 2015 онд Ховд аймгийн Нарсны үнэр ХХК, 2016 онд Баян-Өлгий аймгийн УГУР, Увс аймгийн Улаан шүрэн Чандмань компанууд л чөлөөлөлт эдэлжээ. Эндээс үзэхэд тоног төхөөрөмж оруулж ирж орон нутагт жижиг дунд үйлдвэрлэл явуулж байгаа ААН-үүд байгаа ч хуулийн хөнгөлөлтийг эдэлж чадахгүй мэдлэг, мэдээлэл дутмаг байна.

**1.6 Газрын төлбөрийн тухай хуулийн** заалтын дагуу аймгийн хэмжээнд бүх шатны боловсролын 55 байгууллагын эзэмшилд 71.18 га газрын төлбөрийг чөлөөлсөн байна.

ГХБХБГазрын ирүүлсэн мэдээгээр 2015 онд 986.8 мянган төгрөг, 2016 онд 1110.2 мянган төгрөгийн газрын төлбөрийн хөнгөлөлтийг эдлүүлсэн байна. 2016 оны жилийн эцсийн байдлаар 5416 иргэн 886.2 га эзэмшдэг ба газрын төлбөрийн тухай хуулийн дагуу 841.8 га газрыг татвараас хөнгөлсөн байгаа ч энэ талаар аймгийн татварын албанд нэгтгэсэн судалгаа байхгүй байна.

**1.7 Улсын тэмдэгтийн хураамжийн тухай** хуулиар эдлэх хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар мэдээ судалгаа ОӨУБХэлтэст дараах байдалтай байна.

Хуулийн 41.4 дэх заалтаар тэмдэгтийн хураамжаас иргэд чөлөөлөлт эдэлсэн ч мөн л улирал, жилийн тайлан мэдээнд хөнгөлөлт, чөлөөлөлтийг тусгайлан тусгаж тайлагнадаггүй байна. ОӨУБГ-аас хуулийн дагуу дараахь үйлчилгээг тэмдэгтийн хураамжаас чөлөөлсөн байна. 2015 онд 32, 2016 онд 35 иргэнийн газар өмчлөх эрхийг бүртгэсэн бол 2015 онд 29, 2016 онд 25 иргэнд өвлөгчийн болон өв залгамжлах эрхийн гэрчилгээг олгосон байна.

**1.8 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай:** Үл хөдлөх эд хөрөнгийн татварт гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлсэн газар, газар тариалангийн зориулалтаар иргэнд өмчлүүлсэн газар, нийтийн эзэмшлийн барилга байгууламж, орон сууц, улсаас санхүүждэг хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгө хуулийн дагуу хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлж хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна. Мөн хэдий хэмжээний хөнгөлөлт чөлөөлөлт эдэлж байгаа талаархи нэгдсэн мэдээлэл байхгүй байна.

**1.9 Хувь хүний орлогын албан татварын тухай хуулинд заасан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг холбогдох хуулийн дагуу эдэлж байгаа ч зарим талаар иргэдийн мэдлэг мэдээлэл дутмаг байна.**

1.9.1 ХХОАТ-ын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.15<sup>3</sup>-д заасан татварын чөлөөлөлтийг иргэд эдлээгүй байна. Уг заалт нь 2011 онд нэмэлт өөрчлөлтөөр хуулинд тусгагдсан ч Засгийн газар холбогдох жагсаалтыг батлаагүйгээс өнөөг хүртэл мөрдөгдөөгүй байна. Гэтэл аймгийн хэмжээнд айл өрхийн хэрэгцээнд ашиглаж буй дулаалганы материал, цахилгаан халаагуур, нам даралтын зуухууд байгаа ч татварыг орлогоос чөлөөлөгдөөгүй байна.

ХХОАТ-ын тухай хуулийн 16-р зүйлийн 16.1.12-д заасан 30,0 сая хүртэлх албан татварын чөлөөлөлт, 24-р зүйлийн 24.6, 24.7-д заасан

| № | Он   | Иргэний тоо | Буцаан олголтын дүн /сая төгрөг/ |
|---|------|-------------|----------------------------------|
| 1 | 2016 | 1904        | 818.9                            |
| 2 | 2015 | 1890        | 750.5                            |
|   | Нийт | 3794        | 1569.4                           |

<sup>3</sup> албан татвар төлөгчийн өөрийн хэрэгцээнд зориулан худалдан авсан нар, салхи, газрын гүний дулааны болон бусад сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, нүүрснээс хагас коксон түлш, хийн болон шингэн түлш гарган авах тоног төхөөрөмж, стандартад нийцсэн зуух, нам даралтын зуух, дулаалгын материал, цахилгаан болон хийн халаагуур худалдан авсан баримтаар нотлогдож байгаа төлбөрийн хэмжээтэй тэнцэх орлого

албан татварын хөнгөлөлтийг буцаан олголтоор авч байгаа нь иргэдэд үр дүнтэй хэрэгжиж байна. Албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөнд сүүлийн 2 жилд давхардсан тоогоор 3794 иргэнд 1569.4 сая төгрөгийн татварыг буцаан олгосон байна.

### 1.9.3 Хувь хүний орлогын татварын чөлөөлөлтийг эдлүүлээгүй, судалгаа мэдээлэл хангалтгүй байна.

ХХОАТ-н тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.10-д “Хөгжлийн бэрхшээлийн улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан хувь хүний орлого”-г албан татвараас чөлөөлөхөөр заасны дагуу заалтын хэрэгжилтийг хянахад аймгийн хэмжээнд хуулийн заалт хэрэгжээгүй байна. Хүснэгтээр харуулбал:

| байгууллага | Нийт хөгжлийн<br>бэрхшээлтэй иргэдийн<br>тоо |         | ХЧ-аа 50% алдсан |         | ХЧ-аа 50%-иас дээш<br>алдсан |         |
|-------------|----------------------------------------------|---------|------------------|---------|------------------------------|---------|
|             | 2015 он                                      | 2016 он | 2015 он          | 2016 он | 2015 он                      | 2016 он |
| ЭМНДХэлтэс  | 1962                                         | 1973    | 453              | 447     | 1509                         | 1526    |
| ХХҮХэлтэс   | 1406                                         | 1695    | 810              | 1022    | 596                          | 673     |

Хөдөлмөрийн чадвараа 50%-с дээш алдсан хөдөлмөр эрхлэгч иргэний тоог тодорхойлох боломжгүй байна. ХХОАТ-ын хуульд заасан заалтын дагуу аймгийн хэмжээнд 2015, 2016 онуудад нэг ч иргэнийг чөлөөлөлт эдлүүлээгүй хуулийн заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Аймгийн Татварын хэлтэст дээрх заалтын талаарх судалгаа, мэдээлэл хийгдээгүй байна. Тухайлбал: аймгийн БОЭТ, УЦУОШГ, нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс ажилладаг төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөрийн чадвараа 50%-иас дээш хувиар алдсан иргэнийг хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөхгүй байна.

**1.10 Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн** 8-р зүйлийн 8.3<sup>4</sup>-д заасан төлбөрийн чөлөөлөлтийг иргэд, байгууллагад эдлүүлэхээр заасны дагуу холбогдох чөлөөлөлтийг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2013 оноос хойш үйлдвэрлэсэн, 250 г/км-с бага нүүрсхүчлийн хий ялгаруулдаг 776 авто машинд агаарын бохирдлын төлбөрийн хөнгөлөлт чөлөөлөлтийг татварын программын ноогдуулалтаар чөлөөлөгддөг системтэй байна.

**1.11 Ус бохирдуулсаны төлбөрийн тухай хуулийн** дагуу ус ашигласны төлбөрийг ус ашиглагч нараас авч байгаа бөгөөд Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 2-р хавсралтанд усны нөөц ашигласны төлбөрийн хөнгөлөлт чөлөөлөлтөнд хамрагдах иргэн, аж ахуйн нэгж манай аймагт байхгүй байна. 2015 онд ногоон байгууламж эрхэлж байгаа 18 аж ахуйн нэгж 212107,1 м<sup>3</sup> ус ашиглаж усны төлбөрт 88,6 сая төгрөг, 2016 онд 62084 м<sup>3</sup> усыг 10 аж ахуйн нэгж ашиглаж усны төлбөрт 76,9 сая төгрөгийн төлбөр ногдуулж ажилласан байна.

<sup>4</sup> Энэ хуулийн 7.3-т заасан А-Б ангилалд хамаарах автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн төлбөрийг тухайн автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийг үйлдвэрлэснээс хойшхи эхний 4 жилд чөлөөлнө.  
ҮАГ- ХОА/2017/10-ГА

## **Бүлэг 2:Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд тавих хяналт хангалтгүй байна.**

2.1 Татварын хэлтэст хөнгөлөлт, чөлөөлөлтөнд хамрагдах хуулийн этгээдийн тоо болон үл хөдлөх хөрөнгө, байгалийн баялаг ашигласан төлбөр, усны төлбөр, газрын төлбөр, улсын тэмдэгтийн хураамжийн төлбөрт хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлсэн нэгдсэн мэдээ тайлан аудитад ирүүлсэнгүй.

Мөн татварын ерөнхий хууль, бусад холбогдох хуулиуд заасан хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэрэгжүүлэгч байгууллагуудаас ирүүлсэн судалгааны дүн аймгийн Татварын хэлтэст нэгтгэгдэж мэдээ, судалгаа гаргадаггүй байна. Тухайлбал: Аймгийн ЭМНДХ, ХХҮГ-үүдэд бүртгэлгэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэд чөлөөлөлт эдэлдэггүй, агаарын бохирдлоос чөлөөлөгдсөн автомашины судалгаа гараагүй, ОӨУБХ-ын улсын тэмдэгтийн хураамжийн тоо, чөлөөлөлт тайлагнагдаггүй, ГХБХБГ-наас гаргасан газрын төлбөрийн хөнгөлөлт чөлөөлөлтийн мэдээ судалгаа татварын хэлтэст нэгтгэгдээгүй гэх мэт төрийн байгууллагуудын мэдээлэл, судалгааны дүн харилцан уялдаагүй байна.

Дээрх байдлаас харахад аймгийн Татварын хэлтэс холбогдох төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо сул байна.

2.2 Аймгийн ЗДТГ-ын СТСХ, Татварын хэлтэст сумдуудаас ирүүлж байгаа төсвийн төлөвлөлтөнд хөнгөлөлт, чөлөөлөлтүүдийг тооцохоор байгаа ч 2016 оны төсвийн төсөлд галт зэвсгийн албан татварын тухай хуулиар чөлөөлөгдөх галт зэвсэгийн тоо, түгээмэл тархацтай ашигт малтмал болон байгалийн нөөц ашигласны төлбөрөөс, усны нөөц ашигласны төлбөрөөс хөнгөлөлт чөлөөлөлт эдлэх санал судалгаа ирээгүй байна. Аймгийн татварын орлогын төлөвлөлтөнд ХАОАТ-ын буцаан олголтыг баталж бусад хөнгөлөлт чөлөөлөлтийг тусгайлан зааж батлаагүй байна.

2.3 Татварын хураалт, хөнгөлөлт чөлөөлөлтөд татварын алба хяналт тавихаар заасан байгаа ч өнөөдрийн байдлаар тавьж буй хяналт шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна. Татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн талаар нэгдсэн мэдээ судалгаагүй, ямар хөнгөлөлт, чөлөөлөлт нь эдлэгдээд, ямар нь эдлэгдэхгүй байгаа талаар мэдээлэлгүй, иргэд татвар төлөгч нар хөнгөлөлт, чөлөөлөлтийн хуулийн мэдлэг дутмагаас хуульд заасан эрхээ эдэлж чадахгүй байна.

НӨАТ суутган төлөгчид борлуулалтын орлогоо үнэн зөв чөлөөлж байгаа эсэхэд тавих хяналт сул байгаагаас чөлөөлөлт эдлэх ёсгүй хуулийн заалтуудыг сонгон борлуулалтын орлогыг дур мэдэн бууруулан тайлагнах эрсдэл байна.

### **ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:**

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Иргэд, хуулийн этгээдүүдийн эдлэж байгаа ААНОАТ болон НӨАТ-аас бусад татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг тайлагнах асуудал орхигдсоноос хэдэн иргэн, хуулийн этгээд, хэдий хэмжээний хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн мэдээлэл байхгүй байна.
2. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэрэгжүүлэгч байгууллагуудтай /ЭМНДХ, ХХҮГ, АТГ, ОӨУБХ, ГХБХБГ, Гаалийн газар, БОАЖГ, Шүүх гэх мэт/ харилцан уялдаа холбоо хангалтгүйгээс тоо мэдээллүүд зөрүүтэй, зарим хөнгөлөлт, чөлөөлөлтийг иргэд, байгууллагад эдлүүлээгүй байна. Иргэд хууль эрх зүйн мэдлэг дутмагаасаа хуульд заасан хөнгөлөлт, чөлөөлөлтийг бүрэн эдэлж чадахгүй тохиолдол байна.
3. Татварын хураалт, хөнгөлөлт чөлөөлөлтөд татварын алба хяналт тавихаар заасан байгаа ч өнөөдрийн байдлаар тавьж буй хяналт хангалтгүй байна.
4. НӨАТ суутган төлөгчид борлуулалтын орлогоо үнэн зөв чөлөөлж байгаа эсэхэд тавих хяналт сул байгаагаас чөлөөлөлт эдлэх ёсгүй хуулийн заалтуудыг сонгон борлуулалтын орлогыг дур мэдэн бууруулан тайлагнасан зөрчил нийтлэг байна

## **ЗӨВЛӨМЖ**

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

### **Аймгийн Татварын хэлтсийн дарга Х.Батцэцэг-т:**

1. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэрэгжүүлэгч байгууллагуудтай /ЭМНДХ, ХХҮГ, ТАЗГ, ОӨУБХ, ГХБХБГ, БОАЖГ, Гаалийн газар, Шүүх гэх мэт/ харилцан уялдаа холбоотой ажиллан мэдээллийн сантай болох
2. ХХОАТ-н тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.10-д “Хөгжлийн бэрхшээлийн улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан хувь хүний орлого”-ыг албан татвараас чөлөөлөхөөр заасны дагуу заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах.
3. Иргэдэд хөнгөлөлт чөлөөлөлтийн талаар тэр тусмаа Ховд аймагт эдлэгдэж болох татварын хөнгөлөлтийн талаар сурталчилгааны самбар байрлуулах.
4. Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж хууль сурталчлах цагийг үнэ төлбөргүйгээр цацах талаар аймгийн ИТХ-аар тогтоол гаргуулж хамтран ажиллах.

### **ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Л.ГАЛБАДРАХ

### **ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЦЭГСҮРЭН

### **ТАЙЛАНГ БИЧСЭН:**

АУДИТОР Д.БАЛЖИННЯМ  
АУДИТОР Д.ЭРДЭНЭЦЭЦЭГ

**“Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт,  
үр дүн”-д хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн судалгаа**

сая төгрөг.

| № | Аудитаар илэрсэн                                                                                                                                                                                                            |              | Өгсөн албан шаардлага |     | Тавьсан акт |     | Зөвлөмж |      |
|---|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------|-----------------------|-----|-------------|-----|---------|------|
|   | Зөрчлийн утга                                                                                                                                                                                                               | Зөрчлийн дүн | тоо                   | дүн | тоо         | дүн | тоо     | дүн  |
| 1 | ХХОАТ-н тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.10-д “Хөгжлийн бэрхшээлийн улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан хувь хүний орлого”-г албан татвараас чөлөөлөхөөр заасан ч хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. | 25.0         | 0                     | 0   | 0           | 0   | 1       | 25.0 |
| 2 | Хатан түнхэл ХХК нь НӨАТ-ын хасалт буцаалтын 66,0 сая төгрөгийн худалдан авалтын орлогыг НӨАТ-ын хөнгөлөлт чөлөөлөлтийн орлого гэж буруу тайлагнасан байна.                                                                 | 66.0         | 0                     | 0   | 0           | 0   | 1       | 66.0 |
|   | Нийт дүн                                                                                                                                                                                                                    | 91.0         | 0                     | 0   | 0           | 0   | 2       | 91.0 |

СУДАЛГАА ХИЙСЭН: АУДИТОР

Д.БАЛЖИННЯМ.